



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 0/682

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.в, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 2.6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Цагдаагийн газрын дарга нь 2019 оны 10 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд Бүгд найрамдах Чили Улсын Сантиаго хотноо зохион байгуулагдах “Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага Интерполын Ерөнхий ассамблейн 88 дугаар чуулга”-нд оролцох зардалд 5,000,000 (таван сая), Татварын шинэчлэл-2 аян зохион байгуулах зардалд 3,000,000 (гурван сая) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх зардал 8,000,000 (найман сая) төгрөгийг үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101285